

УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙ

ИЛТГЭХ ХУУДАС

Дугаар 02(2023)

(Улаанбаатар хотын музейн галын аюулгүй байдлын үзлэг, хяналтын мөрөөр авсан арга хэмжээ)

2023 оны 04 дүгээр сарын 25

Улаанбаатар хот





Музейн захирлын 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн “Комисс томилох тухай” А/07 тоот тушаал, Улаанбаатар хотын музейн галын аюулгүй байдлын үзлэг, хяналт хийх тухай удирдамжийн дагуу 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдөр менежер Б.Нарангэрэл, арга зүйч, дотоод хяналт шалгалтын ажилтан Б.Өлзийбаяр, бүртгэл мэдээллийн санч Ч.Өсөхжаргал, дизайнер С.Эрдэнэбат, жижүүр - цахилгаанчин Г.Цолмон нарын бүрэлдэхүүнтэй Улаанбаатар хотын музейн галын аюулгүй байдлын үзлэг, хяналт хийх ажлыг зохион байгуулсан.

Уг ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2011 оны “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” 311 дүгээр тогтоол, Улаанбаатар хотын музейн 2013 оны “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”, Галын аюулгүй байдлын тухай хууль, Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, Монгол улсын стандарт MNS 5634:2006 “Гар урлал болон урлагийн зориулалттай зүйлс. Музейн аюулгүй байдлын шаардлага”, Монгол улсын стандарт MNS 5566:2020 “Гал түймрээс хамгаалах. Аж ахуй нэгж байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм, Улаанбаатар хотын музейн галын аюулгүй байдлын үзлэг, хяналт хийх тухай удирдамжид заасан хүснэгтийн дагуу үзлэг шалгалт хийсэн.

2023 оны 03 дугаар сарын 14-нд галын аюулгүй байдлын үзлэг шалгалтын илтгэх хуудас бичин Музейн захирлын дэргэдэх Захиргааны зөвлөлд танилцуулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээг хууль, дүрэм, журмын хүрээнд авч хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

Энэхүү шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах ажлын хүрээнд Улаанбаатар хотын музейн гадна сарай болон гал унтраах багаж хэрэгслийг шинэчлэн засварлахад шаардагдах зардлын тооцоо гарган музейн захирлаар батлуулан шаардлагатай материалыг худалдан авч уг шалгалтын комиссын гишүүн Г.Цолмон галын сарайг янзлах ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн музейн засвар үйлчилгээ, тоног төхөөрөмж шинэчлэхээр ажиллаж буй Онь Тэнгэрийн бичиг ХХК-иас ажилтнуудын өрөөний цахилгааны утаснуудыг цэгцэлж утас дарагчаар даруулах зэрэг ажлууд хийгдээд байна.

Музейн галын аюулгүй байдлын үзлэг, шалгалтын үеэр илэрсэн зөрчлүүдийг хэрхэн арилгасан тухай хүснэгтээр харуулбал:

Д/д	Илэрсэн зөрчлүүд	Гэрэл зураг (өмнөх байдал)	Гэрэл зураг (дараах байдал)	Зөрчлийг хэрхэн арилгасан
1.	<p>Контор №1 өрөөний сүлжээний утас, цахилгааны утаснууд паарны хажууд байрласан, утас далдлагчгүй, орооцолдсон.</p>			<p>Сүлжээний бүх утсыг цэгцэлж, зориулалтын дарагчаар дарж багцлан цонхны тавцан дээр байрлуулсан.</p>
2.	<p>Контор №2 өрөөнд сүлжээний утас, цахилгааны утаснууд ил, газар байрласан, утас далдлагчгүй, орооцолдсон.</p>			<p>Утсыг цэгцэлж, зориулалтын дарагчаар дарж газраас хөндий байрлуулсан.</p>

3.	Галын сарайг шороон дээр байрлуулсан, дээврээс ус гоождог.			<ul style="list-style-type: none"> - Шалыг тоосго өрж шинээр суулган, цемент цутган тэгшилсэн. - Дээврийг шинээр төмөрлөсөн. - Сарайг бүхэлд нь улаан будгаар будсан.
4.	Гал унтраах төхөөрөмжүүд хуучирч элэгдсэн, шороон дээр байрласан.			<ul style="list-style-type: none"> - Гал унтраах бүх төхөөрөмжийг улаан өнгийн будгаар будсан.

ТАНИЛЦСАН:

ЗАХИРАЛ

П.ДАВААСҮРЭН

ХЯНАСАН:

МЕНЕЖЕР

Б.НАРАНГЭРЭЛ

БОЛОВСРУУЛСАН:

АРГА ЗҮЙЧ

Б.ӨЛЗИЙБАЯР

БОЛОВСРУУЛСАН:

..... Б.ӨЛЗИЙБАЯР (Арга зүйч)

